

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 01

Улаанбаатар

### ТҮЗ-ийн гишүүдийг шинэчлэх тухай

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

#### 1. Компанийн ТҮЗ-ийн аудитын хорооны даргыг дараах байдлаар томилсугай.

1.1. Санал хураалтын дүнг үндэслэн ТҮЗ-ийн аудитын хорооны даргаар Ким Сын Квоныг томилсугай.

2. Хурлын үеэр хувь нийлүүлэгчидийн зүгээс санал оруулснаар ТҮЗ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хилийн чанадад оршин сууж буй гишүүдийн оронд тухайн орон нутагт оршин суугаа иргэдийг томилох шаардлагыг хурлаар авч хэлэлцэн баталсны дагуу дагуу компанийн ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай.

2.1 ТҮЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн А. Баясгалангийн үүрэгт хугацааг дуусгасугай.

2.2 “Хан Майм” ХХК-ийн захирал Ким Сү Намыг нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр шинээр томилсугай.

2.3 Аудитын хорооны дарга Марк Даниелийн үүрэгт хугацааг дуусгасугай.

2.4 ТҮЗ-ийн цалин урамшууллын хорооны гишүүн Х.Хүдэрчулзууны үүрэгт хугацааг дуусгасугай.

2.5 АНУ-ын иргэн Карлос Мэркадог цалин урамшууллын хорооны гишүүнээр шинээр томилсугай.

2.6 ТҮЗ-ийн бусад гишүүдийн бүрэн эрхийг хугацааг 2014 оны ээлжит хурал хүртэл 1 жилийн хугацаатай сунган баталсугай.

3. 2012-2013 онд компанийн зүгээс тодорхой үйл ажиллагаа явуулаагүйтэй холбогдуулан цалин урамшууллын хорооны саналыг үндэслэн гишүүдийн цалин урамшууллыг тухайн онуудад шийдвэрлэх боломжгүй

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

байгааг харгалзан үзэж 2014 оны ээлжит хурал хүртэл цалин олгохгүй байхаар тогтоосугай.

4. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг ТУЗ-ийн дарга болон гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ПАГ ЧАН СҮ

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ

### ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 02

Улаанбаатар

*2012 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг батлах тухай*

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2012 оны компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хүлээн зөвшөөрөн баталсугай.
2. 2012 оны компанийн жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн хүрээнд хурлаар хэлэлцэгдсэн асуудалд бодитой хандан ажиллахыг гүйцэтгэх захирал /Паг Чан Су/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ПАГ ЧАН СУ

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 03

Улаанбаатар

2013 оны үйл ажиллагааны  
ерөнхий төлөвлөгөөг батлах тухай

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2013 оны компанийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хүлээн зөвшөөрөн баталсугай.
2. 2013 оны компанийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хурлаар хэлэлцэн дүгнэсний дагуу өөрчлөн хувьцаа эзэмшигчидийн саналыг тусгаж өөрчлөхийг гүйцэтгэх захирал /Паг Чан Сү/-д даалгасугай.
3. 2013 оны компанийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Паг Чан Сү/-д даалгасугай.
4. Амины орон сууц төсөлд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдэх зорилгоор компанийн давуу эрхийн хувьцаа, эсвэл өрийн бичиг гаргах ажлыг цаашид зохион байгуулж гүйцэтгэх эрхийг компанийн тухай хуулийн 42.1-р заалтыг үндэслэн ТҮЗ-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ПАГ ЧАН СҮ

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 04

Улаанбаатар

“Жэй Эс Би” ХХК-ийг нэгтгэх замаар  
хувьцаа нэмж гаргах тухай

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жэй Эс Би” ХХК-ийг нэгтгэх замаар хувьцаа нэмж гаргах тухай асуудлыг хэлэлцэх нөхцөл бүрдээгүй тул хувьцаа эзэмшигчидийн дараагийн хурлаар хэлэлцэх асуудлаар үлдээсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

ПАГ ЧАН СҮ



# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 05-1

Улаанбаатар

*ХЭХ-ын бусад асуудлын хүрээнд хэлэлцэх*

*асуудлыг тодорхойлох тухай*

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Глобал Монголия Холдингс” ХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэх зорилгоор ХЭХ-ын бусад асуудлын хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг авч хэлэлцүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

ПАГ ЧАН СҮ



# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 05-2

Улаанбаатар

Шууд хөрөнгө оруулалтыг үндэслэн  
нэмж хувьцаа гаргах тухай

“Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлын №5-1 тогтоолын дагуу бусад асуудлын хүрээнд хэлэлцүүлсэн шууд хөрөнгө оруулалтыг үндэслэн нэмж хувьцаа гаргах тухай асуудлыг тооллогын комиссын дүнг үндэслэн дараах байдлаар **ТОГТООХ** нь:

1. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхтэй холбогдуулан нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Нэмэлт хувьцааны нэрлэсэн үнийг 100 төгрөгөөр, тоо ширхэгийг 2,000,000 /хоёр сар ширхэг/байхыг зөвшөөрсүгэй.
3. Нэмэлт хувьцааны доод үнийг 110 /нэг зуун арав/ төгрөг байхыг зөвшөөрсүгэй.
4. Уг төсөл нь хуулийн дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдож байгаа тул компанийн тухай хуулийн 88.1-ийн дагуу ТҮЗ-өөр хэлэлцүүлсүгэй.
5. МУ-ын Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хуль тогжoomж, журмын дагуу “Нэмж хувьцаа гаргах”, холбогдох байгууллагуудад мэдэгдэх, удирдан зохион байгуулах ажлыг гүйцэтгэхийг захирал Паг Чан Сү-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ПАГ ЧАН СҮ

# ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 он 04 сар 22 өдөр

№ 05-3

Улаанбаатар

Тэргүүн ээлжиснд худалдаас авах эрхийг

хэрэгжсүүлэхгүй байх тухай

“Глобал Монголия Холдингс” ХК-ийн 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит хуралд оролцогсодын 100% саналыг үндэслэн ТОГТООХ нь:

- “Глобал Монголия Холдингс” ХК-ийн нэмж хувьцаа гаргах асуудлыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн тухай хуулийн 38.8-р заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчидийн санал нэгтгэйгээр тэргүүн ээлжинд худалдаж авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

ПАГ ЧАН СҮ

